

Агуулга

1. Макро эдийн засгийн орчин
2. Үйл ажиллагааны тайлан
3. Санхүүгийн тайлан

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ОРЧИН



Нэрлэсэн ДНБ*

MNT 82.0 их наяд
USD 24 тэрбум



Гадаад валютын улсын нөөцийн хэмжээ

USD 5.5 тэрбум



Төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл

MNT 776.2 тэрбум
USD 226.9 сая



Нэг хүнд ногдох ДНБ*

MNT 24.0 сая
USD 7,027



Гадаад худалдааны эргэлт

MNT 93.7 их наяд
USD 27.4 тэрбум



Монгол Улсын зээлжих зэрэглэл

"B+", "B+", "B2"
Фитч, Эс энд Пи, Мүүдиз



Бодлогын хүү

10.0%



Инфляц

9.0%



Төлбөрийн тэнцэл**

MNT 128.6 тэрбум
USD 37.6 сая




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк

*Урьдчилсан гүйцэтгэлээр


** 2024 оны 11 сар



ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ (хувь)



ИНФЛЯЦ БА БОДЛОГЫН ХҮҮ (хувь)




- 2024 онд бодит эдийн засаг 5.0% орчим өсөж, нэрлэсэн ДНБ урьдчилсан гүйцэтгэлээр 82.0 их наяд төгрөгт хүрлээ. Эдийн засгийн өсөлтөд уул уурхайн салбар, түүнийг дагасан салбарын идэвхжил нэмэгдсэн нь эерэг нөлөө үзүүлэв. Харин хөдөө аж ахуйн салбарт тулгарсан хүндрэл нь эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөллөө.
- 2025 онд нүүрсний экспортын тоо хэмжээ хэвээр хадгалагдаж, Оюутолгойн зэс, алтны гарц нэмэгдэхээс гадна хөдөө аж ахуйн салбарын сэргэлттэй холбоотой эдийн засгийн өсөлт 6.2%-д хүрэх төлөвтэй байна.

- Худалдааны түнш орнуудын инфляц буурч, валютын ханш тогтворжсонтой холбоотой импортын гаралтай бараа бүтээгдэхүүний үнэ буурсан нь улсын хэмжээнд инфляцын эрч саарч 2024 оны 6 сард 5.1%-д хүрэхэд нөлөөлөв. Гэсэн хэдий ч 2024 оны эцэст эдийн засгийн идэвхжил, төсвийн тэлэх бодлогын нөлөөгөөр дотоод эрэлт нэмэгдсэнээр инфляцын түвшин өсөж 9.0%-д хүрлээ.
- 2024 оны эхний хагаст инфляц буурч 5.1%-д хүрч, зорилт түвшинд тогтворжсонтой холбоотой дунд хугацаанд эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжих зорилгоор Монголбанк бодлогын хүүг 3 нэгж хувиар бууруулж 10% хүргэв.




ГАДААД ХУДАЛДАА (сая ам.доллар)



ГАДААД ВАЛЮТЫН УЛСЫН НӨӨЦ БА ВАЛЮТЫН ХАНШ

(Гадаад валютын улсын албан нөөц, сая ам.доллар (баруун тэнхлэг), валютын ханш (зүүн тэнхлэг))



- 2024 онд гадаад худалдааны тэнцэл ӨОМУ-ээс 29.7% (1.8 тэрбум ам.доллар) буурч 4.2 тэрбум ам.долларын ашигтай гарлаа. Энэхүү бууралтад импортын өсөлт нь экспортын өсөлтөөс хурдацтай нэмэгдсэн нь голлон нөлөөлөв.
- 2024 онд нийт экспортын хэмжээ ӨОМУ-ээс 3.9% (596 сая ам.доллар) өсөж 15.8 тэрбум ам.долларт хүрэв. Нийт экспортын 55% нүүрсний экспорт дангаараа бүрдүүлсэн ба 2024 онд нийт 83.8 сая тонн нүүрс экспортолсон байна.

- 2024 оны 12 сарын байдлаар гадаад валютын улсын нөөц (ГВУН) ӨОМУ-ээс 11.8% (588 сая ам.доллар) өсөж 5.5 тэрбум ам.долларт буюу түүхэн дээд хэмжээнд хүрлээ. Үүнд олон улсын санхүүжилт нэмэгдэхийн сацуу экспортын орлого өссөн нь голлон нөлөөллөө.
- 2024 онд ЗГ-ын зүгээс хуваарьт бондын өр төлбөрүүдийг амжилттай дахин санхүүжүүлсэн, экспортын орлого өндөрт хадгалагдаж, ГВУН түүхэн дээд түвшинд хүрсэн нь төгрөгийн ханш ам.долларын эсрэг тогтвортой байхад голлон нөлөөлөв.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



2024-2026 ГОЛЛОХ ЧИГЛЭЛ

ХАРИЛЦАГЧИЙН ТУРШЛАГА



- Хялбар найдвартай цахим сувгийн туршлагыг бүх сегментийн харилцагчдадаа хүргэнэ.
- Харилцагчийн туршлагын олон улсын IDCXS стандартын дагуу харилцагчийн үйлчилгээний процессыг сайжруулна.
- Харилцагчийн санхүүгийн боловсролыг хиймэл оюунд суурилсан чат бот ашиглан сайжруулна.
- Хиймэл оюун, машин сургалтад суурилан бүтээгдэхүүн үйлчилгээг сайжруулна.



БИЗНЕС ӨСӨЛТ ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА



- Зээлийн багцыг тэнцвэртэй өсгөнө.
- Ногоон зээлийн багцыг нийт багцдаа 10%-д хүргэнэ.
- Хувийн банкны үйлчилгээг сайжруулна.
- Олон улсын стандартад нийцсэн эрсдэлийн удирдлагын тогтолцоог хэрэгжүүлж, хүлэмжийн хийн ялгаралтыг хэмжиж, ил тод болгоно.
- Кибер эрсдэл, уур амьсгалын эрсдэл, биет эрсдэл зэрэгт онцгой анхаарч, байгууллагын нэгдсэн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлнэ.



ЦАХИМ БАНК



- Цахим худалдааны төлбөр тооцооны туршлагыг хялбарчилж, цахим хэтэвч хөгжүүлнэ.
- Харилцагчийн амьдралын хэв маягт нийцсэн, бизнесийн үйл ажиллагаанд нийцсэн төлбөр тооцооны экосистем бүрдүүлнэ.
- Цахим бүтээгдэхүүн тогтмол үйлчилгээг сайжруулна.
- Санхүүгийн хүртээмжийг шинэлэг технологи ашиглана.
- Үйл ажиллагааны процесс автоматжуулалтыг сайжруулна.



БАЙГУУЛЛАГЫН ХӨГЖИЛ



- ХААН Банкны тогтвортой хөгжлийн бодлогыг ТХЗ болон ҮТХН-д нийцүүлэн өргөжүүлнэ.
- Ажилтны туршлага, эерэг орчин сэтгэл ханамж, хөдөлмөр эрхлэлтийн тэгш байдалд анхаарна.
- Тогтвортой хүний нөөцийн туршлагыг хэрэгжүүлнэ.
- Олон улсын стандартад нийцсэн БОНЗ тайлагналыг боловсруулна.
- Тогтвортой нийгмийн хөрөнгө оруулалт, компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд тогтвортой хөгжлийн 17 зорилгод хувь нэмрээ оруулах.



ХАРИЛЦАГЧИЙН ТУРШЛАГА



Стратеги: Хялбар, шуурхай, найдвартай омни-сүвгийн туршлага



Харилцагч төвтэй аргачлал



Туршлага төвтэй аргачлал

Сүвгүүд

Апп
Веб
Киоск
АТМ

Омни сүвгийн нэвтрүүлэлт

Омни-сүвгийн туршлагыг сайжруулах

ҮНТ-ийн хөгжүүлэлтүүд

ҮНТ-ийн сайжруулалт

Зайнаас ажиллах агентууд

Салбар

Салбарууд; "Digi Go"- Цахим салбар

ҮА-ны стандарт

ОУХТуршлагын стандарт



Бүх суваг дээрх цахим туслах

- "Digi Go"-Цахим салбар
- Орон нутаг дахь ЖДБ төвүүд

Сегментэд тулгуурласан туршлага & ОУ-ын стандартад нийцүүлэх (ЖДБ & Корпорэйт)

Харилцагч бүрийн хүсэлд нийцсэн бүтээгдэхүүн санал болгох



Хиймэл оюун, өгөгдлийн шинжилгээ ба технологид тулгуурлах



Борлуулалтын чиглэл

Бүтээгдэхүүн санал болгох



Бүтээгдэхүүний цар хүрээг нэмэх

Тогтвортой бүтээгдэхүүн



Сегментчилэл: Харилцагчийн үнэ цэнд төвлөрсөн аргачлал



ХАА-ЫН КЛАСТЕР, БИЗНЕС ЭРХЛЭГЧИЙГ ДЭМЖСЭН ШИНЭ БҮТЭЭГДЭХҮҮН



НООЛУУРЫН НЭМҮҮ ӨРТГИЙН
СҮЛЖЭЭГ ДЭМЖИХ ЗЭЭЛ



ҮР ТАРИАНЫ НЭМҮҮ ӨРТГИЙН
СҮЛЖЭЭГ ДЭМЖИХ ЗЭЭЛ



СҮҮНИЙ ЧИГЛЭЛД КЛАСТЕРЫН
СҮЛЖЭЭГ ДЭМЖИХ ЗЭЭЛ



МАХНЫ ЧИГЛЭЛД КЛАСТЕРЫН
СҮЛЖЭЭГ ДЭМЖИХ ЗЭЭЛ

ТОГВОРТОЙ САНХҮҮЖИЛТИЙГ ДЭМЖСЭН ШИНЭ БҮТЭЭГДЭХҮҮН



ТОГВОРТОЙ НООС,
НООЛУУРЫН НИЙЛҮҮЛЭЛТИЙГ
ДЭМЖИХ НОГООН ЗЭЭЛ



ЭМЭГТЭЙ БИЗНЕС ЭРХЛЭГЧИЙН
ЦАХИМ ШИЛЖИЛТИЙГ ДЭМЖИХ
БИЗНЕСИЙН ЗЭЭЛ



МАЛЧДЫН ХЭРЭГЛЭЭНИЙ
НОГООН ЗЭЭЛ



ХАРИУЦЛАГАТАЙ МАЛЧНЫ
НОГООН ЗЭЭЛ

ТОГВОРТОЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫГ ДЭМЖСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Тогтвортой хөгжлийн стратегийн зөвлөх үйлчилгээ, “Уур амьсгалын зөвлөх үйлчилгээ”-үүдийг авч тогтвортой хөгжлийн бодлого, уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг арга хэмжээ авах чиглэлд суурь хөрөнгө оруулалт хийсээр байна.

Ногоон технологийн шалгуур хангасан бараа бүтээгдэхүүн, үйлдвэрлэгч бэлтгэн нийлүүлэгчийн мэдээллийг нэг дор багтаасан [Green.khanbank.com](https://www.greenkhanbank.com) онлайн платформ нэвтрүүлээ.

Компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд байгаль орчин, нийгэм ба хөгжил, эрүүл мэнд, боловсрол чиглэлээр **520 гаруй төсөл хөтөлбөрт 15.9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгээд байна.**




КАРТЫН РЕБРЭНДИНГ ХИЙЖ, ШИНЭ БҮТЭЭГДЭХҮҮНҮҮД НЭВТРҮҮЛЛЭЭ



Монголын анхны LED гэрэлтэй төлбөрийн картыг Олон улсын олимпын хорооны тусгай зөвшөөрөлтэйгөөр цөөн тоогоор харилцагчдадаа санал болголоо.



Easy Кредит картын бүтээгдэхүүнийг нэвтрүүлснээр харилцагчид өр орлогын харьцаа хамаарахгүй бэлэн мөнгөний зээлийн картаар шууд үйлчлүүлэх боломжтой боллоо.



Монголын анхны хөдөлгөөнт виртуал карт "Digi карт"-ыг нэвтрүүлж, 18-аас дээш насны харилцагчдад зориулан гаргалаа.



ХААН Банк ЮнионПэй картын харилцагчдадаа зориулж Алтан гэрэгэнээс сэдэвлэн бүтээсэн "SplendorPlus" алтан картыг шинээр нэвтрүүлээ.


ШИНЭЛЭГ ЦАХИМ БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭГ ЗАХ ЗЭЭЛД НЭВТРҮҮЛЛЭЭ



Харилцагчдын төлбөр тооцоог хялбарчлах шимтгэлгүй, урамшуулалтай, цорын ганц, дахин давтагдашгүй, өөрийн илэрхийлэл болох Digitag-ыг үүсгэж гүйлгээ хийх DIGI PAY-г амжилттай нэвтрүүллээ. 2024 оны 12 сарын байдлаар **240 мянга** гаруй харилцагч ашиглан гүйлгээг хялбараар хийж байна.



Гар утасны NFC-ээр дамжуулан картын контактлесс буюу зайнаас унших технологийг ашиглан хэзээ ч, хаана ч төлбөр тооцоогоо хялбар хүлээн авах боломжийг ХААН Банк нээж, цахим ПОС буюу DiGi POS аппликэйшнийг үйлчилгээндээ нэвтрүүлсэн. 2024 оны 12-р сарын байдлаар **15,000 гаруй** картаар үйлчлүүлэгч байгууллага ашиглаж байна.



Хиймэл оюунд суурилсан Digi цахим туслах нэвтэрснээр бид харилцагчдынхаа цагийг хэмнэх, байгаа газраасаа гар утсаа ашиглан хэрэгцээт мэдээллээ олж авах боломжийг бүрдүүлж, харилцагчдадаа илүү түргэн шуурхай хүрч үйлчилж байна. Үйлчилгээ нэвтэрснээр **61,000 гаруй** лавлагаанд Digi цахим туслах хариуцсан байна.

ЦАХИМ ХАРИЛЦАГЧИЙН ТОО БОЛОН ХЭРЭГЛЭЭНИЙ ИДЭВХ ТОГТМОЛ ӨССӨӨР БАЙНА.

2.9 сая	1.9 сая	1.9 сая	75 мян	458	1,262
НИЙТ ХАРИЛЦАГЧ	ЦАХИМ ХАРИЛЦАГЧ	КАРТ ЭЗЭМШИГЧ	ПОС*	КИОСК	АТМ

*ПОС, Дижитал Пос, Статик QR



**ХААН БАНК САЛБАРТАА
АНХЛАН ИННОВАЦИЙН ТӨВӨӨ
БАЙГУУЛЛАА.**



**ХААН БАНКНЫ СӨҮЛ ОФФИС
ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТ БҮХИЙ
ЗАГВАР ОФФИС БОЛЛОО.**




**"SIBOS-2024"-Т АРИЛЖААНЫ
БАНКУУДЫГ ТӨЛӨӨЛЖ ХАМТРАН
ОРОЛЦЛОО.**



**ХААНБАНК ЖДБИЗНЕСИЙН
АКАДЕМИАР 3,300* БИЗНЕС
ЭРХЛЭГЧИЙГ ЧАДАВХЖУУЛАВ.**



**ХААН БАНК DIGIPAY ЦАХИМ
ХЭТЭВЧИЙГ АМЖИЛТТАЙ
НЭВТРҮҮЛЛЭЭ.**



**ALIPAY+ ҮЙЛЧИЛГЭЭ
НЭВТРҮҮЛЛЭЭ.
"ГАДААД ГҮЙВУУЛГА"**



**ХААН БАНК "ТОГТВОРТОЙ
САНХҮҮГИЙН ФОРУМ" ЗОХИОН
БАЙГУУЛЛАА**



**ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛД АНХ
УДАА НИЙГМИЙН БОНД ГАРГАЛАА.**



**21 АЙМАГТ "БИЗНЕС ТӨВ"
БАЙГУУЛАВ.**



**BNY MELLON-Д АМ.ДОЛЛАРЫН
ДАНС НЭЭЛЭЭ.**


САНХҮҮГИЙН ГҮЙЦЭТГЭЛ



САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД


НИЙТ ХӨРӨНГӨ

(тэрбум төгрөг)




НИЙТ ЗЭЭЛ

(тэрбум төгрөг)




НИЙТ ТТХ

(тэрбум төгрөг)



НИЙТ ӨӨРИЙН ХӨРӨНГӨ

(тэрбум төгрөг)



ЗАХ ЗЭЭЛ ЭЗЛЭЛТ (2024 оны 12-р сарын 31-ний байдлаар, Монголбанкны тайлагналын дагуу тооцсон)

НИЙТ ХӨРӨНГӨ




20.3
их наяд төгрөг
28.4%

НИЙТ ЗЭЭЛ




11.9
их наяд төгрөг
32.4%

ХАРИЛЦАГЧИЙН ДЕПОЗИТ



13.9
их наяд төгрөг
31.3%

НИЙТ ЦЭВЭР АШИГ




639
тэрбум төгрөг
37.1%




НИЙТ ЗЭЭЛ*

(тэрбум төгрөг)




БИЗНЕСИЙН ЗЭЭЛ

(тэрбум төгрөг)



ХЭРЭГЛЭЭНИЙ ЗЭЭЛ

(тэрбум төгрөг)



ОРОН СУУЦНЫ ЗЭЭЛ

(тэрбум төгрөг)



* Монгол банкны тайлангийн аргачлалын дагуу

НОГООН ЗЭЭЛИЙН БАГЦ

712 тэрбум
+124%

НОГООН ЗЭЭЛИЙН ЭЗЛЭХ ХУВЬ

6%

Зорилт: 10%

БАЙГУУЛЛАГЫН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

- ХААН Банкны Өөрийн хөрөнгийн хүрэлцээг дотооддоо үнэлэх үйл явц (ICAAP) болон Хөрвөх чадварын хүрэлцээг дотооддоо үнэлэх үйл явц (ILAAP)-ыг эрсдэлийн удирдлагын тогтолцоод нэвтрүүлсэн ба туршилтын тайлангуудыг боловсруулан зохицуулагч байгууллагад хүргүүлсэн байна.
- ISO 27001:2022, ISO 27701:2019, болон SOC 2 аудит нь интернэт банкны үйлчилгээний бүрэн аюулгүй байдлыг баталгаажуулах зорилгоор амжилттай хийгдсэн байна
- Шинээр мөнгө угаахтай тэмцэх онлайн сэрэмжлүүлгийн систем (QUARTZ) нэвтрүүлсэн.

ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛ

- Зээлдэгчийн эрсдэлд суурилсан шийдвэр гаргалтын моделиудад үндэслэн онлайн зээлийг хөгжүүлж байна.
- Бенчмаркт үндэслэн онлайн ЖДБизнесийн зээлийн хэмжээг 100 сая төгрөг болгон нэмэгдүүлсэн.

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛЭЭС ТАТСАН САНХҮҮЖИЛТ



2024 ОНД ОЛОН УЛСЫН ЗАХ
ЗЭЭЛЭЭС ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН
САНХҮҮЖИЛТ

\$331,250,000



НИЙГМИЙН БОЛОН НОГООН
САНХҮҮЖИЛТ

USD 177 САЯ

ЭМЭГТЭЙ БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙГ
ДЭМЖИХ

USD 71 САЯ

БИЧИЛ, ЖДБ-ИЙГ ДЭМЖИХ

USD 83.25 САЯ

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛД
ГАРГАСАН МОНГОЛ УЛСЫН АНХНЫ
НИЙГМИЙН БОНД*

\$130,000,000



НОГООН САНХҮҮЖИЛТ
БОЛОН ЖДБ ЭРХЛЭГЧДИЙГ
ДЭМЖИХ

\$40,000,000



НОГООН БИЗНЕС, ЭМЭГТЭЙ
БИЗНЕС ЭРХЛЭГЧИД, БИЧИЛ БОЛОН
ЖДБ ЭРХЛЭГЧДИЙГ ДЭМЖИХ

\$31,000,000



БИЧИЛ БОЛОН ЖИЖИГ ДУНД
БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙГ
ДЭМЖИХ

\$27,500,000



*НИЙГМИЙН БОНД гэдэг нь тогтвортой санхүүжилтийн шинэлэг хэрэгсэл бөгөөд нийгмийн суурь үйлчилгээ болох боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ, хүнсний аюулгүй байдал, тогтвортой хүнсний систем болон ЖДБ эрхлэгчдийг дэмжих, мөн орон сууц болон суурь дэд бүтэц рүү чиглэсэн нийгмийн үр өгөөжтэй, зорилтот төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх зориулалттай юм.

"ДОТООДЫН НОГООН БОНД
ХӨТӨЛБӨР"-ИЙН
АМ.ДОЛЛАРЫН ТРАНЧ

\$25,000,000



НОГООН БИЗНЕС БОЛОН
ЭМЭГТЭЙ БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙГ
ДЭМЖИХ

\$30,000,000



БИЧИЛ БОЛОН ЖИЖИГ ДУНД
БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙГ
ДЭМЖИХ

\$20,500,000



ЭМЭГТЭЙ БИЗНЕС ЭРХЛЭГЧИД,
БИЧИЛ БОЛОН ЖИЖИГ ДУНД
БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙГ ДЭМЖИХ

\$20,000,000



БИЧИЛ БОЛОН ЖИЖИГ ДУНД
БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙГ
ДЭМЖИХ

\$4,000,000



БИЧИЛ БОЛОН ЖДБ
ЭРХЛЭГЧДИЙГ ДЭМЖИХ


\$3,250,000






ТАТВАРЫН ДАРААХ ЦЭВЭР АШИГ

(тэрбум төгрөг)




АКТИВЫН ӨГӨӨЖ, %

(Сүүлийн 12 сарын дундаж активаар тооцсон)




ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ӨГӨӨЖ, %


(Сүүлийн 12 сарын дундаж активаар тооцсон)




ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ХҮРЭЛЦЭЭ, %



ХӨРВӨХ ЧАДВАРЫН ХАРЬЦАА, %



ЧАНАРГҮЙ ЗЭЭЛИЙН ХАРЬЦАА, %





- Үүлэн технологийн шинэчлэлт - 4.3 тэрбум төгрөг
- Өгөгдлийн нөөцлөлт, технологийн хүчин чадлыг нэмэгдүүлэх - 6 тэрбум төгрөг
- Дижитал шилжилт - 13.9 тэрбум төгрөг
- Цахим аюулгүй байдал болон Процесс автоматжуулалтууд - 5.1 тэрбум төгрөг
- Цахим бүтээгдэхүүний хөгжүүлэлт, сайжруулалтад - 34.8 тэрбум төгрөг

Цахим шилжилт, мэдээлэл технологийн хөрөнгө оруулалт

Нийт: **64.1** тэрбум төгрөг

Зарцуулалт:
100%

- Бид эрчим хүчний хэмнэлттэй барилгыг санхүүжүүлэх, гэр хороолол, зуслангийн бүсэд амьдарч буй иргэдийн амьдрах орчноо сайжруулахад чиглэсэн урт хугацаат, таатай нөхцөл бүхий ногоон зээлийн бүтээгдэхүүнийг гарган зах зээлд нэвтрүүлсэн.

Ногоон төсөл, хөтөлбөрүүдийн санхүүжилт

Нийт: **62.4** тэрбум төгрөг

Зарцуулалт:
100%

- Урт хугацаат хөрөнгө оруулалтын зээлийн санхүүжилт 258 харилцагчийн 56.9 тэрбум төгрөгийн 36-84 сарын хугацаатай хөрөнгө оруулалтын зээлүүдийг олгосон.


Орон сууц, хөрөнгө оруулалтын санхүүжилт

Нийт: **56.9** тэрбум төгрөг

Зарцуулалт:
100%



[MSE: KHAN]



- “ХААН Банк” ХК нь 2023 онд 558.8 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж, үүний 48.5% болох нийт 271 тэрбум төгрөг буюу нэгж хувьцаанд 141.73 төгрөгийн ногдол ашгийг 2024 оны 4 сарын 23-нд хувьцаа эзэмшигчдэдээ мөнгөн хэлбэрээр хуваарилав.
 - Dividend yield (DY) = 11.77% /FY2023-ны эцсийн ханшаар тооцов/
- 2025 оны 1 сарын 29-ний ХААН Банк ХК-ны хувьцааны хаалтын ханш 1,203 төгрөг. (2023 оны эцсийн хаалтын ханш = ₮1,204).
 - 2024 оны 6 сарын 18-ны өдөр доод цэгтээ (₮1,008) хүрсэн бөгөөд үүнээс хойш 2025 оны 1 сарын 29 хүртэл **19.35%**-иар өслөө.



Нэгж хувьцаанд хуваарилагдах ногдол ашиг:

195.35 төгрөг

2025.02.13:

Ногдол ашиг хуваарилах ТУЗ-ийн шийдвэр

2025 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдөр:

Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр

Ногдол ашиг хуваарилах огноо:

Монголбанкнаас холбогдох зөвшөөрлийг хүлээн авснаас хойш ажлын 5 өдрийн дотор

2024 оны татварын дараах цэвэр ашиг:


638,514,456,614 төгрөг

2024 оны татварын дараах цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах хувь:

58.5%

Хуваарилах ногдол ашгийн нийт дүн:

373,547,879,300 төгрөг





3 удаа

ТУЗ-ийн
биечилсэн хурал

6 удаа

ТУЗ-ийн цахим
хурал

5 удаа

ТУЗ-ийн
Аудитын хороо

3 удаа

ТУЗ-ийн
Засаглал, Цалин
Урамшууллын
хороо

5 удаа

ТУЗ-ийн
Нэр дэвшүүлэх,
Хүний нөөцийн
хороо

4 удаа

ТУЗ-ийн
Эрсдэлийн
хороо

Шинээр хэлэлцэн баталсан:

- Ногоон бондын хөтөлбөрт нэмэлт өөрчлөлт оруулах тухай
- ХААН Банк ХК-ийн Хөрөнгө оруулагчидтай харилцах бодлого
- 2023 оны Ногдол ашиг хуваарилах тухай
- ТУЗ-ийн хороодын бүтэц, бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай
- ХААН Банк ХК-ийн Шүгэл үлээх бодлого
- Залилангийн удирдлагын хөтөлбөр
- Банкны шинэчилсэн зохион байгуулалтын бүтэц
- ОУСК Нийгмийн бонд
- ХААН Банк ХК-ийн Мэдээллийн ил тод байдал, тайлагналын бодлого



БАЯРЛАЛАА.